



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 466

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Багануурын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, нийт 5,829,621.69 (таван сая найман зуун хорин есөн мянга зургаан зуун хорин нэгэн төгрөг жаран есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Багануурын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Ганбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэг, материал болгон ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ"-ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ҮНДСЭН ХӨРӨНГӨ

6098169 1118202983

Д/Д	Хөрөнгийн нэр /байршил/	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бурийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Трансформатор КТП-1600 W	1981.01.01	1	975 195,66	975 195,66		975 195,66
2	Гэрлийн удирдах щит	1980.10.01	3	8 142,01	24 426,03		24 426,03
3	Тоолуур DSS112 100В	2008.01.22	9	120 000,00	1 080 000,00		1 080 000,00
4	Электроавтомат /секц холбогч/	1997.01.01	1	3 750 000,00	3 750 000,00		3 750 000,00
				4,853,337.67	5,829,621.69		5,829,621.69
				(дөрвөн сая найман зуун тавин гурван мянга турван зуун гучин долоон төгрөг жаран есөн мөнгө)	(таван сая найман зуун хорин есөн мянга зургаан зуун хорин нэгэн төгрөг жаран есөн мөнгө)		(таван сая найман зуун хорин есөн мянга зургаан зуун хорин нэгэн төгрөг жаран есөн мөнгө)
	Дүн	-	14				